

24 дүгээр зүйл

Оролцогч улсууд энэхүү Конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэгдсэн шаардлагатай бүх арга хэмжээг үндэсний түвшинд батлана.

25 дугаар зүйл

1 Энэхүү Конвенц бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргыг энэхүү Конвенцийн хадгалагчаар томилно.

3 Энэхүү Конвенцийг соёрхон батална. Соёрхон батласан батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

4 Энэхүү Конвенц бүх улс нэгдэн ороход нээлттэй байна. Нэгдэн орсон батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орсон хэмээн үзнэ.

26 дугаар зүйл

1 Энэхүү Конвенцийг хянаж өөрчлөх тухай хүсэлтийг аливаа оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр хэдийд ч гаргаж болно.

2 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей ийм төрлийн хүсэлттэй холбогдуулж авах арга хэмжээ байгаа бол уг арга хэмжээний талаар шийдвэр гаргана.

27 дугаар зүйл

1 Энэхүү Конвенц нь хорь дахь соёрхон батласан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдөр хүчин төгөлдөр болно.

2 Хорь дахь соёрхон батласан буюу нэгдэн орсон батламж жуух бичгийг хадгалуулсны дараа энэхүү Конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн орсон улсын хувьд батламж жуух бичгээ хадгалуулсан өдрөөс хойш гуч дахь өдөр энэхүү Конвенц хүчин төгөлдөр болно.

28 дугаар зүйл

1 Конвенцийг соёрхон батлах буюу нэгдэн ороходоо оролцогч улсаас хийсэн тайлбарын эх бичвэрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авч, бүх улсад хүргүүлнэ.

2 Энэхүү Конвенцийн зорилго, зорилгод харшилсан тайлбар хийхийг зөвшөөрөхгүй.

3 Тайлбарыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад зохих ёсоор мэдэгдэж хэдийд ч буцаан авч болох бөгөөд Ерөнхий нарийн

бичгийн дарга энэ тухай бүх улсад мэдэгдэнэ. Тайлбарыг буцаан авах тухай мэдэгдэнэ нь түүнийг хүлээн авсан өдөр хүчин төгөлдөр болно.

29 дүгээр зүйл

1 Энэхүү Конвенцийг тайлбарлах буюу хэрэгдэх талаар оролцогч хоёр буюу түүнээс дээш улсын хооронд үүссэн маргааныг хэлэлцээний журмаар шийдвэрлэж чудаагүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр арбитраар шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ. Ийнхүү хүсэлт гаргаснаас хойш зургаан сарын дотор талууд арбитрын бүрэлдэхүүний талаар тохиролцож чадахгүй бол аль нэг тал маргааныг Олон улсын шүүхэд түүний дүрмийн дагуу хүсэлт гарган шилжүүлж болно.

2 Аливаа оролцогч улс энэхүү Конвенцид гарын үсэг зурах, түүнийг соёрхон батлах эсхүл түүнд нэгдэн ороходоо энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт түүний хувьд үйлчлэхгүйг мэдэгдэж болно. Тийм тайлбар хийсэн аливаа оролцогч улстай холбоотойгоор оролцогч бусад улсын хувьд энэ хэсгийн заалт үйлчлэхгүй.

3 Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тайлбар хийсэн аливаа оролцогч улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж уг тайлбарыг хэдийд ч буцааж болно.

30 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн араб, хятад, англи, франц, орос болон испани хэлээр үйлдсэн эх бичвэр нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

7. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ
КОНВЕНЦИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛ

1999 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж,
2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хүчин төгөлдөр болсон¹

Энэхүү Протоколд оролцогч улсууд,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнэ болон эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэйд итгэдгээ дахин нотолсныг тэмдэглэж;

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүн бүр нэр төр, эрхийн хувьд тэгш, эрх чөлөөтэй төрдөг бөгөөд тус тунхаглалд заасан бүхий л эрх чөлөөг хүн бүр аливаа ялгаваргүйгээр, тухайлбал хүйсээр ялгаварлалгүйгээр эдлэх ёстой хэмээн тунхагласныг тэмдэглэж;

хүйсээр алагчилахыг хориглосон хүний эрхийн тухай олон улсын пактууд болон олон улсын бусад баримт бичгийг харгалзан үзэж;

түүнчлэн Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцид оролцогч улсууд эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг буруушаан, эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгахад чиглэсэн бодлогыг зохистой бүхий л аргаар нэн даруй явуулахаар тохиролцсныг мөн харгалзан үзэж;

¹ Монгол Улс 2000.09.07-нд гарын үсэг зурж, 2001.12.14-нд соёрхон батласан

хүний эрх, үндсэн эрх чөлөөгөөр эмэгтэйчүүдийг бүрэн тэгш хангах, эдгээр эрх чөлөөг зөрчихгүй байх талаар үр нөлөөтэй арга хэмжээ авах шийдвэр төгс байгаагаа нотлож;

дараахь зүйлийг тохиролцов:

1 дүгээр зүйл

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах хороо (цаашид "Хороо" гэж нэрлэнэ) 2 дугаар зүйлийн дагуу мэдээллийг хүлээн авч, хэлэлцэх бүрэн эрхтэйг энэхүү Протоколд оролцогч улс (цаашид "оролцогч улс" гэж нэрлэнэ) хүлээн зөвшөөрнө.

2 дугаар зүйл

Оролцогч улс Конвенцид заасан аливаа эрхийг зөрчсөний улмаас хохирсон тухай аливаа мэдээллийг оролцогч улсын хуулинд захирагдах этгээд, бүлэг этгээд буюу тэдгээрийн нэрийн өмнөөс өгч болно. Хэрэв мэдээллийг нэг буюу бүлэг этгээдийн нэрийн өмнөөс өгөх бол ийнхүү мэдээлэл өгч буй этгээд нь зөвшөөрөлгүйгээр тэднийг төлөөлөх болсноо нотлохоос бусад тохиолдолд тэдний зөвшөөрснөөр уг мэдээллийг өгнө.

3 дугаар зүйл

Мэдээллийг бичгээр гаргах бөгөөд нэргүй мэдээлэл өгч болохгүй. Энэхүү Протоколд нэгдэн ороогүй Конвенцид оролцогч улстай холбоотой мэдээллийг Хороо хүлээн авахгүй.

4 дүгээр зүйл

1. Эрх зүйн хамгаалалтын аргыг ашиглах нь шалтгаангүйгээр удааширсан буюу санасан үр дүнд хүрээгүйн улмаас болон бусад тохиолдолд дотоодын эрх зүйн бололцоотой бүхий л хамгаалалтын аргыг ашигласан тухай мэдэгдэхээс өмнө Хороо мэдээллийг хэлэлцэхгүй.

2. Дараахь тохиолдолд Хороо мэдээллийг хэлэлцэх боломжгүйд тооцно:

a) уг асуудлыг Хороо хянан хэлэлцсэн буюу хянан хэлэлцэж байгаа, эсхүл олон улсын магадлах буюу зохицуулах өөр журмын дагуу хянан үзэж байгаа бол;

b) мэдээлэл Конвенцийн заалтад нийцэхгүй байгаа бол;

c) мэдээлэл үндэслэлгүй буюу үндэслэл нь хангалтгүй байвал;

d) мэдээлэл нь мэдээлэл өгөх эрхийг урвуулан ашигласан бол;

e) мэдээлэлд дурдсан баримт холбогдох оролцогч улсын хувьд энэхүү Протокол хүчин төгөлдөр болохоос өмнө тохиолдсон буюу дурдсан хугацаанаас хойш гараагүй бол.

5 дугаар зүйл

1. Хороо мэдээллийг хүлээн авсны дараа ямар ч үед болон түүний зарчмын шийдвэр гаргахаасаа өмнө холбогдох оролцогч улсад хандаж, эрх зөрчигдсөн байж болзошгүй хохирогч буюу хохирогчдоод барагдашгүй хохирчлуулахгүй байх үүднээс тухайн оролцогч улсаас зайлшгүй шаардлагатай түүнийг хэмжээ авахыг хүсч болно.

2. Хэрэв хороо энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу өөрийн эрх мэдлээр хүрээнд багтах эрхээ эдлэж байгаа тохиолдолд энэ нь мэдээллийг хүлээн авч болно гэж буюу түүний талаар зарчмын шийдвэр гаргасан хэрэг биш болно.

6 дугаар зүйл

1. Хороо оролцогч холбогдох улсыг нэрлэхгүйгээр мэдээллийг хүлээн авч боломжгүй гэж үзэх бөгөөд мэдээлэгч этгээд өөрийн нэр буюу бусад нэр оролцогч энэхүү улсад мэдэгдэхээс бусад тохиолдолд хороо энэхүү Протоколын дүрмүүдээр аливаа мэдээллийг оролцогч холбогдох улсад мэдээллийн нууцлал хангалзсан байдлаар хүргэнэ.

2. Мэдээллийг хүлээн авагч оролцогч улс уг асуудалтай холбоотой аливаа хэмжээ авсан бол тэр тухайгаа тайлбар буюу мэдэгдэл бичгээр гаргаж, зургаан сар дотор Хороонд хүргүүлнэ.

7 дугаар зүйл

1. Хороо энэхүү Протоколын дагуу хүлээн авсан мэдээллийг авч хэлэлцэх холбогдох талуудад ийм мэдээлэл илгээсэн байвал хувь этгээд буюу бүлэг этгээд өмнө тэдний нэрийн өмнөөс болон холбогдох оролцогч улсаас хороонд ирүүлэх бүхий л мэдээллийг харгалзан үзнэ.

2. Энэхүү Протоколд заасан мэдээллийг Хороо хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ.

3. Хороо мэдээллийг судалсны дараа түүний талаархи саналаа зөвлөмжийн хэлбэрээр холбогдох талуудад илгээнэ.

4. Оролцогч улс хорооны санал, зөвлөмжийг хэлэлцэж, түүнийг харгалзсан үндсэн дээр авсан аливаа арга хэмжээний тухай мэдээллийг оролцуулан 6 сар дотор хороонд хариуг бичгээр ирүүлнэ.

5. Оролцогч улсаас Хорооны санал, зөвлөмжийн хариуд авсан аливаа арга хэмжээний тухай нэмэлт мэдээллийг ирүүлэх, тухайлбал Хороо шаардлагатай үзвэл Конвенцийн 18 дугаар зүйлийн дагуу ирүүлэх дараагийн тайланд тусгай оролцогч улсад мэдэгдэж болно.

8 дугаар зүйл

1. Конвенцид заасан эрхийг оролцогч улс нойтойгоор удаа дараа зөрчиж байгаа тухай баталгаатай мэдээллийг Хороо хүлээн авсан бол мэдээллийг шалгахад хамт оролцож, холбогдох мэдээллийн талаархи саналаа ирүүлэхийг оролцогч улсаас хүсч болно.

2. Оролцогч холбогдох улсаас ирүүлж болох аливаа санал, гүүнчлэн Хороонд байгаа баталгаатай бусад мэдээллийг харгалзан Хороо хянан шалгах ажиллагаа явуулж, дүнг яаралтай илтгэх зорилгоор нэг буюу хэд хэдэн гишүүнээ томилж болно. Шаардлагатай гэж үзсэн бөгөөд оролцогч улс зөвшөөрсөн тохиолдолд тухайн улсын нутаг дэвсгэрт очиж, хянан шалгах ажиллагаа явуулж болно.

3. Тэрхүү хянан шалгах ажиллагааны дүнг судлаж үзсэний дараа Хороо уг дүнг санал зөвлөмжийнхөө хамт холбогдох оролцогч улсад хүргүүлнэ.

4. Хорооноос илгээсэн дүн, санал, зөвлөмжийг хүлээн авснаас хойш 6 сарын дотор холбогдох оролцогч улс Хороонд хариу илгээнэ.

5. Хянан шалгах ажиллагааг нууцлалыг хадгалсан байдлаар явуулах бөгөөд энэ ажлын бүхий л үе шатад оролцогч улсын зүгээс хамтын ажиллагааг хангах бүхий л арга хэмжээ авна.

9 дүгээр зүйл

1. Энэхүү Протоколын 8 дугаар зүйлийн дагуу явуулсан хянан шалгах ажиллагаатай холбогдуулан авсан аливаа арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Конвенцийн 18 дугаар зүйлийн дагуу ирүүлэх тайландаа тусгахыг Хорооноос оролцогч холбогдох улсад мэдэгдэж болно.

2. Шаардлагатай бол 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дурдсан 6 сарын хугацаа дууссаны дараа хянан шалгах ажиллагаатай холбогдуулан авсан арга хэмжээний тухай мэдээлэхийг Хорооноос оролцогч холбогдох улсад мэдэгдэж болно.

10 дугаар зүйл

1. Оролцогч аливаа улс энэхүү Протоколд нэгдэн ороходоо 8, 9 дүгээр зүйлд заасан Хорооны бүрэн эрхийг зөвшөөрөхгүй байгаагаа мэдэгдэж болно.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтын дагуу мэдэгдэл хийсэн оролцогч аливаа улс Ерөнхий нарийн бичгийн даргад уламжлах замаар уг мэдэгдлээсээ хэдийд ч татгалзаж болно.

11 дүгээр зүйл

Энэхүү Протоколын дагуу хороонд мэдээлэл ирүүлсний улмаас тухайн улсын хуульд захирагдах этгээдтэй зүй бусаар харьцах буюу айлган сүрдүүлэхгүй байх үүднээс оролцогч улс шаардлагатай бүхий л арга хэмжээ авна.

12 дугаар зүйл

Энэхүү Протоколын дагуу хийсэн ажлын товч тайланг Хороо Конвенцийн 21 дүгээр зүйлийн дагуу ирүүлэх жил бүрийн тайландаа оруулна.

13 дугаар зүйл

Оролцогч улс бүр Конвенц болон энэхүү Протоколыг өргөнөөр сурталчилж, ид тод байлгахын хамт хорооны санал, зөвлөмжийн тухай, тухайлбал оролцогч тухайн улстай холбогдсон асуудлын тухай мэдээллийг хүртээлтэй болгоход тус дөхөм үзүүлэх үүрэг хүлээнэ.

14 дүгээр зүйл

Энэхүү Протоколоор хороонд хүлээлгэсэн үүргийг биелүүлэхийн тулд мөрдөх журмыг хорооноос тогтооно.

15 дугаар зүйл

1. Конвенцид гарын үсэг зурсан, соёрхон батласан буюу нэгдэн орсон аливаа улс энэхүү Протоколд гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Нэгдэн орсон тухай батламж жуух бичгээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаар нэгдэн орсонд тооцно.

3. Конвенцийн соёрхон батласан буюу нэгдэн орсон аливаа улс энэхүү Протоколыг соёрхон батална. Соёрхон батласан тухай батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

4. Конвенцийг соёрхон батласан буюу нэгдэн орсон аливаа улс энэхүү Протоколд нэгдэн ороход нээлттэй байна.

16 дугаар зүйл

1. Нэгдэн орсон арав дахь батламж жуух бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулснаас хойш 3 сарын дараа энэхүү Протокол хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Протоколыг хүчин төгөлдөр болсны дараа түүнд нэгдэн орсон улс бүрийн хувьд өөрийн нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 3 сарын дараа энэхүү Протокол хүчин төгөлдөр болно.

17 дугаар зүйл

Энэхүү Протоколд тайлбар хийж үл болно.

18 дугаар зүйл

1. Энэхүү Протоколд оролцогч аливаа улс түүнд нэмэлт өөрчлөлт оруулах санал дэвшүүлж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга санал болгосон нэмэлт өөрчлөлтийг Протоколд оролцогч улсуудад уламжилж, уг саналыг хэлэлцэж санал хураах зорилгоор оролцогч улсуудын бага хурал хуралдуулах эсэхээ түүнд буюу тус байгууллагад мэдэгдэхийг хүснэ. Хэрэв оролцогч улсуудын гуравны нэгээс доошгүй хувь нь бага хурал хуралдуулахыг дэмжвэл Ерөнхий нарийн бичгийн дарга уг бага хурлыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын ивээл дор хуралдуулна. Уг бага хуралд оролцсон хийгээд саналаа өгсөн оролцогч улсын олонхи нь зөвшөөрсөн аливаа нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейд өргөн мэдүүлнэ.

2. Нэмэлт өөрчлөлтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей баталж, энэхүү Протоколд оролцогч улсуудын гуравны хоёр нь үндэстний хууль тогтоомжийн дагуу хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.

3. Ийнхүү хүчин төгөлдөр болсон нэмэлт өөрчлөлтийг Протоколд оролцогч батласан улсууд нь заавал дагаж мөрдөх үүрэгтэй бөгөөд харин оролцогч бусад улс энэхүү Протоколын заалт болон өмнө батласан аливаа заалтын мөрдөнө.

19 дүгээр зүйл

1. Оролцогч аливаа улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэж, энэхүү Протоколыг хэдийд ч цуцалж болно. Уг мэдэгдлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авснаас хойш 6 сарын дараа Протокол тухайн улсын хувьд хүчингүй болно.

2. Протоколын цуцлалт хүчин төгөлдөр болохоос өмнө 2 дугаар зүйлийн дагуу ирүүлсэн аливаа мэдээллийн хувьд энэхүү Протоколын заалтыг үргэлжлүүлэн мөрдөх буюу 8 дугаар зүйлийн дагуу эхэлсэн аливаа хянан шалгах ажиллагааг хэрэгжүүлэхэд саад болохгүй байна.

20 дугаар зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга:

- а) энэхүү Протоколд гарын үсэг зурсан, соёрхон батласан, нэгдэн орсон тухай;
- б) энэхүү Протокол хүчин төгөлдөр болсон өдөр, 18 дугаар зүйлийн дагуу түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн тухай;
- в) 19 дүгээр зүйлийн дагуу хийсэн аливаа цуцлалтын тухай бүх улсад мэдэгдэнэ.

21 дүгээр зүйл

1. Энэхүү Протоколыг англи, араб, испани, орос, франц, хятад хэлээр үйлдсэн эх бичвэрүүд нь адил хүчинтэй бөгөөд түүнийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын архивт хадгална.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Протоколын баталгаат хуулбарыг Конвенцийн 25 дугаар зүйлд заасан бүх улсад хүргүүлнэ.

**8. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ
КОНВЕНЦИЙН 20 ДУГААР ЗҮЙЛИЙН 1 ДЭХ ХЭСЭГТ ОРУУЛСАН НЭМЭЛТ
ӨӨРЧЛӨЛТ**

1995 оны 12 дугаар сарын 22-ны өдөр батласан*

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцид оролцогч улсууд,

Ерөнхий Ассамблейн 1994 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийг батлах тухай 49/164 дүгээр тогтоолыг санаж,

* Монгол Улс 1997.10.03-нд соёрхон батласан

дээрх Конвенцийн 26 дугаар зүйлийн дагуу Дани, Финлянд, Исланд, Норвеги, Шведийн Засгийн газрууд тухайн Конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан "жил бүр хоёр долоо хоногоос дээшгүй хугацаагаар хуралдана" гэсний оронд "жил бүр шаардлагатай хугацаагаар" гэсэн нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал дэвшүүлснийг гэмдэглэж,

Ерөнхий Ассамблейн 1994 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 49/448 дугаар тогтоолд Ерөнхий Ассамблей дээрх Конвенцийн 26 дугаар зүйлийн дагуу оролцогч улсыг хурлын явцад оруулах аливаа нэмэлт өөрчлөлтийг анхаарч, Конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн аливаа нэмэлт өөрчлөлтийн цар хүрээг хязгаарлахыг хүссэнийг мөн тэмдэглэж,

дээрх Конвенцийн ач холбогдол болон эмэгтэйчүүдийг алагчилахыг устгахад хүчин чармайлт гаргаж буй Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хорооны хувь нэмрийг дахин сануулж,

Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хорооны ажлын ачаалал Конвенцид оролцогч улсын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор өсөж байгаа бөгөөд тухайн хорооны жилийн хуралдаан нь хүний эрхийн бусад гэрээний дагуух байгууллагын жилд хуралддаг хуралдаанаас хамгийн богино байгааг тэмдэглэж,

Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хороо 14 дүгээр хуралдаанаараа батласан 22 дахь Зөвлөмжийг санаж,

Хороо нь өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд оролцогч улсын танилцуулсан тайлангийн бүрэн гүйцэд болон цаг хугацаандаа ирсэн эсэхийг харгалзан, тэдгээрийн Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх арга хэмжээг батлах шаардлагатайг итгүүлж,

Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хорооны хуралдаан цаг хугацааны хувьд хангалттай байх нөхцөл нь ирээдүйд Хорооны үр дүнг баталгаажуулах чухал хүчин зүйл болохыг мөн итгүүлж,

1. Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан зүйлд дараахь нэмэлт өөрчлөлтийг оруулахаар шийдэв:

"Дээрх конвенцийн 18 дугаар зүйлийн дагуу хороонд танилцуулсан тайланг хэлэлцэх зорилгоор жил бүр ердийн хугацаагаар хуралдана. Хорооны хуралдааны үргэлжлэх хугацаа дээрх Конвенцид оролцогч улсууд хуралдаанаараа тогтоож, үүнийг нь Ерөнхий Ассамблейн сайшааснаар тодорхойлно."

2. Ерөнхий Ассамблей 15 дугаар чуулганаараа тухайн нэмэлт өөрчлөлтийг сайшааж байгааг тэмдэглэхийг зөвлөж,

3. Нэмэлт өөрчлөлт нь Ерөнхий Ассамблейн зохих хэлэлцүүлгээр болон Ерөнхий нарийн бичгийн даргад Конвенц хадгалуулсан оролцогч улсуудын хоёрны гурав нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хүчин төгөлдөр болохоор шийдэв.